

ᠳᠣᠷᠨᠣᠳ ᠠᠶᠢᠮᠠᠭ ᠳᠠᠬᠤ ᠲᠥᠷᠢᠶᠢᠨ
ᠠᠭᠳᠢᠲᠤ ᠭᠠᠰᠠᠷ

ДОРНОД АЙМАГ ДАХЬ ТӨРИЙН
АУДИТЫН ГАЗАР



**ДОРНОД АЙМГИЙН
2024 ОНЫ ТӨСВИЙН
ТӨСӨЛД ӨГСӨН
АУДИТЫН ДҮГНЭЛТ
/хураангуй тайлан/**

2023 оны 11 дүгээр сар

Товчилсон үгийн тайлбар.....	3
Хүснэгтийн товъёг	4
Зорилт, хамарсан хүрээ, арга зүйн талаарх мэдэгдэл.....	5
Бүлэг 1. Аймгийн 2024 оны төсвийн төсөл нь аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй нийцсэн байна	6
Бүлэг 2. Төсвийн төслийг сангийн яамнаас ирүүлсэн төсвийн хязгаартай уялдуулан боловсруулсан байна.....	6-8
Бүлэг 3. Аймгийн 2024 оны төсвийн орлогыг өмнөх оноос 13,858.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөсөн байна.....	8
✓ Орлогын төлөвлөлт.....	8
✓ Зарлагын төлөвлөлт.....	9
✓ Орон нутгийн хөрөнгө оруулалт.....	9
✓ Хөрөнгө оруулалт бус хөтөлбөр, төсөл арга хэмжээ	11
✓ Орон нутгийн хөгжлийн сан	12
✓ Байгаль хамгаалах нөхөн сэргээх зардал	12-14
✓ Авто замын сан	14
✓ Хөдөө аж ахуйн сан	14
✓ Халамжийн сан.....	15
✓ Төсвийн тэнцэл	15
✓ Өмнөх зөвлөмжийн хэрэгжилт.....	16
Холбогдох байгууллагын санал	17-18
Саналд өгсөн тайлбар	18 -20
Дүгнэлт.....	20
Зөвлөмж	20
Төсвийн төсөлд өгөх санал.....	21
Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын тушаал	22

Товчилсон үгийн тайлбар:

АДБОУС	Аудитын дээд байгууллагын олон улсын стандарт
АЗДТГ	Аймгийн Засаг даргын Тамгын газар
БОХНСЗ	Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардал
ЗГ	Засгийн газар
ЗДТГ	Засаг даргын Тамгын газар
ИТХ	Иргэдийн Төлөөлөгчдийн Хурал
МУЗЗННТУТХ	Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хууль
ОНХС	Орон нутгийн хөгжлийн сан
ОНХНС	Орон нутгийн хөгжлийн нэгдсэн сан
СТСХ	Санхүү, төрийн сангийн хэлтэс
ТЕЗ	Төсвийн ерөнхийлөн захирагч
ТЭЗҮ	Техник эдийн засгийн үзүүлэлт

Хүснэгтийн товъёг:

№	Тайлбар	Хуудасны дугаар
Хүснэгт 1	Сангийн яамны орлогын хянасан хязгаар болон орон нутгийн төсөвт төвлөрүүлэх орлогын харьцуулалт	6
Хүснэгт 2	Сангийн яамны зарлагын хянасан хязгаар болон төсвийн ерөнхийлөн захирагчийн төлөвлөсөн зарлагын харьцуулалт	7
Хүснэгт 3	Орлогын 2023 оны батлагдсан төсөвтэй 2024 оны орлогын төсвийн төслийг харьцуулбал.	8
Хүснэгт 4	Зарлагын 2024 оны төсвийн төслийг 2023 оны төсвийн төсөлтэй харьцуулбал.	9

Аудит хийх үндэслэл,
бүрэн эрх:

Аудитын зорилт:

Зорилт, хамарсан хүрээ, арга зүйн талаарх мэдэгдэл:

Төрийн аудитын тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.3.2, Төсвийн тухай хуулийн 8 дугаар зүйлийн 8.5.1 дэх заалт, УИХ-ын Төсвийн байнгын хорооны 2022 оны “Аудитын сэдэв батлах тухай” 09 дүгээр тогтоол, Монгол Улсын Ерөнхий аудиторов “Аудитын жилийн төлөвлөгөө батлах тухай” 2023 оны А/04 дүгээр тушаалын дагуу Төрийн аудитын тухай хуульд заасан бүрэн эрхийн хүрээнд аудитыг гүйцэтгэлээ.

Төсвийн ерөнхийлөн захирагчийн өргөн мэдүүлсэн Дорнод аймгийн 2024 оны төсвийн төсөл нь арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэй, төрийн санхүүгийн удирдлагыг сайжруулан эдийн засгийн тогтвортой хөгжлийг хангах, холбогдох шалгуур үзүүлэлтүүдэд нийцсэн эсэхийг хангахад зорилт чиглэгдлээ. Үүнд:

- ✓ Төсвийн төсөл нь аймгийн хөгжлийн бодлогод нийцсэн эсэх;
- ✓ Төсвийн төсөл нь Төсвийн тухай хууль тогтоомжид заасан шалгуурыг хангасан эсэх;
- ✓ Төсвийн орлогыг бодит тооцоо, судалгаанд үндэслэлтэй төлөвлөсөн эсэх;
- ✓ Төсвийн урсгал зарлагыг үр дүнд суурилсан арга аргачлалаар, Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцүүлж хэмнэлттэй, үр ашигтай байхаар төлөвлөсөн эсэх;
- ✓ Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар санхүүжүүлэх төсөл, арга хэмжээг хөгжлийн бодлогын баримт бичигт нийцүүлэн, ач холбогдлоор эрэмбэлж, хууль болон эдийн засгийн үр өгөөжтэй байх шаардлагад нийцүүлэн төлөвлөсөн эсэх;
- ✓ Төсвийн төслийн тэнцвэржүүлсэн тэнцэл (ашиг, алдагдал)-ийг үндэслэлтэй тооцож, хуулийн шаардлагад нийцүүлж төлөвлөсөн эсэх

Хамрах хүрээ:

Аудитыг Дорнод аймгийн 2024 оны төсвийн төсөл, 2021, 2022, 2023 оны төсвийн гүйцэтгэл /батлагдсан болон урьдчилсан/, төсвийн шууд захирагчид болон төсөл, хөтөлбөрүүдийн үйл ажиллагааны үр дүнгийн үзүүлэлтүүд, төрийн болон төрийн өмчийн оролцоотой хуулийн этгээдүүдийн үйл ажиллагааг хамруулан гүйцэтгэв.

Аудитын шалгуур
үзүүлэлт, арга зүй:

Аудитын явцад АДБОУС, нийтээр хүлээн зөвшөөрсөн зарчимд тулгуурласан Төрийн аудит MNS 6817:2020 Монгол Улсын стандарт, Монгол Улсын Ерөнхий аудиторов 2020 оны А/106 дугаар тушаалаар баталсан “Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам”, 2022 оны А/67 дугаар тушаалаар батлагдсан “төсвийн төсөлд дүгнэлт гаргах аргачлал” болон бусад заавар, аргачлал, гарын авлагыг мөрдөж ажиллав. Дээрх стандарт, арга зүйн дагуу аудитын үе шатны ажлыг гүйцэтгэж, аудитын дүн, дүгнэлтийг дэмжих нотлох зүйлсийг зохих журмын дагуу цуглуулж ажлын баримт материалд хавсаргасан болно. Аудитад төсөв боловсруулах, өргөн мэдүүлэх, батлах ажиллагаатай холбоотой хууль тогтоомж, журам, заавар аргачлал, түүний дотор Төсвийн тухай хуулийн 5 дугаар бүлэг, Хөгжлийн бодлого төлөвлөлт, түүний удирдлагын хуулийн 6.9-д заасан шаардлагыг гол шалгуур болголоо.

Аудитыг гүйцэтгэсэн
бүрэлдэхүүн, хугацаа:

Аудитыг Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудитор Б.Болортуул удирдаж, үе шатны чанарын хяналтыг аудитын менежер И.Сэмжидмаа хэрэгжүүлж, ахлах аудитор Д.Нармандах, Б.Батжаргал, Я.Зориг, аудитор Б.Одхүү, С.Энхбаатар, М.Ухаанбилэг, Б.Оюунхэрлэн, М.Ганбилэг, Г.Ганбилэг нар гүйцэтгэв.

Талбарын ажлыг 2023 оны 11 дүгээр сарын 21-ний өдрөөс эхлүүлж, санал, дүгнэлтийг аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга М.Энхтөрд 2023 оны 12 дугаар сарын 01-ны өдөр хүргүүллээ.

БҮЛЭГ 1. АЙМГИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙН ТӨСӨЛ НЬ АЙМГИЙГ ХӨГЖҮҮЛЭХ ТАВАН ЖИЛИЙН ҮНДСЭН ЧИГЛЭЛ, АЙМГИЙН ХӨГЖЛИЙН ЖИЛИЙН ТӨЛӨВЛӨГӨӨТЭЙ НИЙЦСЭН БАЙНА.

“Аймаг, нийслэл, хотыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл” гэж Монгол Улсыг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, Хөгжлийн зорилтот хөтөлбөрт суурилсан орон нутгийн онцлогийг тусгасан дунд хугацааны төлөвлөлтийн баримт бичгийг хэлнэ. /Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7/

Аймгийн 2024 оны төсвийн төсөл нь аймгийн Засаг даргын 2020-2024 оны үйл ажиллагааны мөрийн хөтөлбөр, эдийн засаг, нийгмийг 2021-2025 онд хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, урт хугацааны Дорнод аймгийн 2016-2025 оны хөгжлийн хэтийн зорилт, богино хугацааны Дорнод аймгийн 2024 оны хөгжлийн жилийн төлөвлөгөө зэрэг бодлогын баримт бичгүүдтэй нийцсэн байна.

БҮЛЭГ 2. ТӨСВИЙН ТӨСЛИЙГ САНГИЙН ЯАМНААС ИРҮҮЛСЭН ТӨСВИЙН ХЯЗГААРТАЙ УЯЛДУУЛАН БОЛОВСРУУЛСАН БАЙНА.

Төсвийн тусгай шаардлага, дунд хугацааны төсвийн хүрээний мэдэгдэлд нийцүүлэн төсвийн ерөнхийлөн захирагчийн тухайн жилийн төсөв боловсруулахад баримтлах орлогын доод хэмжээ, зарлагын дээд хэмжээг **“жилийн төсвийн хязгаар”** гэнэ. /Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.8/

Аймгийн 2024 оны төсвийн төсөлд төсвийн орлогыг 92,348.4 сая төгрөгөөр төсөвлөн нь Сангийн яамны хянаж ирүүлсэн дүнгээс 18,153.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэн боловсруулсан байна.

Аймгийн төсвийн тэнцвэржүүлсэн ба тусламжийн орлогыг 18.2 тэрбум төгрөгөөр нэмэгдүүлэхдээ татварын орлого 3.8 тэрбум төгрөг, татварын бус орлого 5.1 тэрбум төгрөг, тусламжийн орлого 4.8 тэрбум төгрөг, урьд оны үлдэгдлээс 4.5 тэрбум төгрөгөөр тус тус нэмэгдүүлэн тооцсон байна.

Аймгийн 2024 оны төсвийн төсөлд нийт зарлагыг 89,371.9 сая төгрөгөөр төсөвлөн нь Сангийн яамны хянаж ирүүлсэн хязгаараас 18,153.8 сая төгрөгөөр нэмэгдсэн байна.

Сангийн яамны хянасан төсөв, аймгийн 2024 оны төсвийн төслийг харьцуулан үзэхэд нийт зардлыг 18,153.8 сая төгрөгөөр нэмэгдүүлэхдээ орон нутгийн төсвийн байгууллагуудын зардлыг 838.8 сая төгрөгөөр, аймаг, сумын орон нутгийн хөгжлийн сан 7,548.2 сая төгрөгөөр, орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтын зардал 7,175.7 сая төгрөгөөр, ойн анги 55.5 сая төгрөгөөр, авто замын сан 300.5 сая төгрөгөөр, Аймгийн Засаг даргын ерөнхий дансны зарлага 726.4 сая төгрөгөөр, сангийн яамнаас хянагдаагүй аймгийн зардалд 1,508.7 сая төгрөгийг тус тус нэмэгдүүлэн төлөвлөсөн байна.

ДҮГНЭЛТ: Төсвийн төслийг сангийн яамнаас ирүүлсэн төсвийн хязгаарыг баримтлан боловсруулсан байна.

БҮЛЭГ 3. АЙМГИЙН 2024 ОНЫ ТӨСВИЙН ОРЛОГЫГ ӨМНӨХ ОНООС 13,858.6 САЯ ТӨГРӨГӨӨР НЭМЭГДҮҮЛЭН ТӨЛӨВЛӨСӨН БАЙНА.

Төсвийн орлогын төлөвлөлт:

“Төсвийн орлого” гэж хууль тогтоомжийн дагуу улсын болон орон нутгийн төсөв бүрдүүлэх орлого, төсвийн байгууллагын өөрийн үйл ажиллагааны орлогыг хэлнэ” /Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.9/

Орон нутгийн 2024 оны төсвийн орлогыг 92,348.4 сая төгрөг буюу өмнөх оноос 18 хувиар нэмэгдүүлэн төлөвлөсөн байна.

ДҮГНЭЛТ: Аймгийн 2024 оны төсвийн орлогыг өмнөх оноос 13,858.6 сая төгрөгөөр нэмэгдүүлэн төлөвлөсөн байна.

Төсвийн зарлагын төлөвлөлт:

“Төсвийн зарлага” гэж төсөв захирагчийн үйл ажиллагаа, хэрэгжүүлэх хөтөлбөр, төсөл, арга хэмжээг санхүүжүүлэхээр батлагдсан төсвөөс хуваарилан, зарцуулах хөрөнгийг” хэлнэ. /Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.10/

Аймгийн 2024 оны төсвийн нийт зарлагыг 2023 оны төсвийн төслийн дүнгээс 28,373.3 сая төгрөгөөр буюу 46.4 хувиар нэмэгдүүлэн төлөвлөсөн байна. Үүнээс бараа, ажил үйлчилгээний зардлыг 87.1 хувиар, хөрөнгийн зардлыг 28.7 хувиар нэмэгдүүлэн, урсгал шилжүүлгийг 17.9 хувиар бууруулан төлөвлөсөн байна.

Аймгийн 2024 оны төсвийн төсөлд тусгасан төсвийн байгууллагуудын цалингийн тооцоололд горим сорил хэрэгжүүлэхэд АЗДТГ-ын төсөвт засаг даргын зөвлөхийн нэг орон тоонд 18.8 сая төгрөгийн цалин, нийгмийн даатгалын шимтгэлийг зарцуулахаар төлөвлөсөн байна.

ДҮГНЭЛТ: Аймгийн Засаг даргын зөвлөхийн нэг орон тоонд 18.8 сая төгрөгийн цалин, нийгмийн даатгалын шимтгэлийг зарцуулахаар төлөвлөсөн байна.

САНАЛ: Аймгийн Засаг даргын зөвлөхийн нэг орон тоонд зарцуулахаар төлөвлөсөн цалин, нийгмийн даатгалын шимтгэлийн 18.8 сая төгрөгийг хасах саналтай байна.

Орон нутгийн хөрөнгө оруулалт:

Аймгийн орон нутгийн 2024 оны төсвийн төслийн 2 дугаар хавсралтад нийт хөрөнгө оруулалтын шинжтэй 11,403.6 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 24 төсөл, арга хэмжээ байхаар төлөвлөж, 1,432.7 сая төгрөгийг өмнөх оны 7 төсөл, арга хэмжээнд зарцуулахаар, шинээр хэрэгжүүлэх барилга, байгууламж, их засвар, тоног төхөөрөмж, зураг төсвийн зардалд 9,970.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 17 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Мөн төсвийн төслийн 4 дүгээр хавсралтаар 3,046.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 12 барилгын их засварын ажлыг төлөвлөсөн байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний шилжих хөрөнгийн ангиллын 1.1.9 дэх 140.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Хэвтээ тэнхлэгийн хойд болон урд авто замд хурд сааруулагч хийх, тэмдэглэгээ шинэчлэх (Хэрлэн сум)” ажил нь Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22 дугаар зүйлийн 22.1.20¹-д зааснаар сумын чиг үүрэгт хамаарахаар байна.

Төрийн болон орон нутгийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах тухай хуулийн 11 дүгээр зүйлийн 11.1, 11.1.1, 11.1.2, 11.1.3, 11.1.4, Засгийн газрын 2023 оны 278 дугаар тогтоолоор баталсан “Төсвийн хөрөнгө оруулалтаар хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээг төлөвлөх, санхүүжүүлэх, хянах, тайлагнах журам”-ын 3.1.4, 3.1.4.4, 3.1.4.5-д заасантай нийцэхгүй байна.

Тоног төхөөрөмж ангилалд байгаа 1,474.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 9 төсөл, арга хэмжээ байгаагаас техникийн тодорхойлолт боловсруулах шаардлагад нийцээгүй 1,455.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 төсөл, арга хэмжээ байна.

¹ 22.1.20.орон нутгийн зам, гүүр, тэмдэг, тэмдэглэгээ, арчлалт, хамгаалалт;

ДҮГНЭЛТ: Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22.1.20 дахь сумын чиг үүрэгт хамаарах 140.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл, арга хэмжээг төлөвлөж, техникийн тодорхойлолтыг хууль, журмын дагуу боловсруулаагүй төлөвлөсөн 1,455.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 төсөл, арга хэмжээ байна.

САНАЛ: Төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор техникийн тодорхойлолтод сайжруулалт хийх шаардлагатай нийт 1,455.1 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 8 төсөл, арга хэмжээ байна.

ЗӨВЛӨМЖ: Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан аймаг, орон нутгийн чиг үүрэгт хамаарах төсөл, арга хэмжээг төлөвлөх, Төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг сайжруулж, техникийн тодорхойлолтыг хууль, журамд нийцүүлэн боловсруулах.

Орон нутгийн хөрөнгө оруулалтын бус төсөл, арга хэмжээ:

Аймгийн орон нутгийн 2024 оны төсвийн төсөлд 2 дугаар хавсралтаар нийт хөрөнгө оруулалтын бус шинжтэй 3,219.2 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 71 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна.

Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалтаар Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 21 дүгээр зүйл дэх аймгийн хэрэгжүүлэх чиг үүрэгт хамаарахгүй, Төсвийн тухай хуулийн 31 дүгээр зүйлийн 31.1.4 дэх хөрөнгө оруулалтын арга хэмжээ, түүнд шаардагдах хөрөнгийн хэмжээг холбогдох хөтөлбөрт тусгаагүй, Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.2.6 дахь заалтыг баримтлаагүй 4 төсөл, арга хэмжээг тус тус төлөвлөсөн байна.

ДҮГНЭЛТ: Төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор сайжруулалт хийж, батлуулах нийт 423.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 4 төсөл, арга хэмжээ байна.

ЗӨВЛӨМЖ: Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуульд заасан аймаг, орон нутгийн чиг үүрэгт хамаарах төсөл, арга хэмжээг төлөвлөх, Төсвийн тухай хуульд зааснаар хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө түүнд шаардагдах хөрөнгийн хэмжээг холбогдох хөтөлбөрт тусган батлуулах.

САНАЛ: Төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор сайжруулалт хийж, батлуулах нийт 463,4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 төсөл, арга хэмжээ байна. Үүнд:

Орон нутгийн хөгжлийн сан:

Аймгийн 2024 оны төсвийн төсөлд ОНХС-гийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэхээр 14.8 тэрбум төгрөгийн 79 төсөл арга хэмжээ төлөвлөж, 2,878.2 сая төгрөгийг өмнөх оны 16 төсөл, арга хэмжээнд зарцуулахаар, шинээр хэрэгжүүлэх 11,951.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 63 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнд: Их засварт 1,448.8 сая төгрөгийн 11 төсөл арга хэмжээ, барилга байгууламжид 4,578.1 сая төгрөгийн 14 төсөл арга хэмжээ, тоног төхөөрөмжид 2,106.3 сая төгрөгийн 13 төсөл арга хэмжээ, ТЭЗҮ зураг төсөвт 100.0 сая төгрөг, хөрөнгө оруулалтын бус арга хэмжээнд 3,718.7 сая төгрөгийн 24 төсөл арга хэмжээ байна.

Аймгийн 2024 оны төсвийн төсөлд батлагдсан зураг төсвөөс зөрүүтэй Гурванзагал сумын Эрүүл мэндийн төвийн барилгын засварт 81.5 сая төгрөг төлөвлөсөн байна. Энэ нь Төсвийн тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.4 “Хөрөнгө оруулалтын төсөвт

техник, эдийн засгийн үндэслэл хийгдсэн, зураг төсвөө батлуулсан, хуульд заасан бусад зөвшөөрөл олгогдсон төсөл, арга хэмжээг тусгана.” гэсэн заалттай нийцэхгүй байна.

ЗӨВЛӨМЖ: Төсвийн тухай хуульд зааснаар хөрөнгө оруулалтын төсөл, арга хэмжээг төлөвлөхдөө зураг, төсвөө батлуулсан төсөл, арга хэмжээг тусган батлуулах.

САНАЛ: Төсвийн санхүүжилтийн үр ашгийг дээшлүүлэх нийт 81.5 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээний саналыг оруулж байна.

Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх сан:

Аймгийн 2024 оны төсвийн төсөлд байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлаар 2,116.9 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 27 төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнд: Өмнөх оноос шилжин ирсэн 287.5 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээ, шинээр хэрэгжүүлэх 1,829.4 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 24 төсөл, арга хэмжээ.

ДҮГНЭЛТ: Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлаар 2024 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтад Монгол Улсын Засаг захиргаа, нутаг дэвсгэрийн нэгж, түүний удирдлагын тухай хуулийн 22.1.13, 22.1.8 дахь сумын чиг үүрэгт хамаарах 325.0 сая төгрөгийн 3 төсөл, журамд нийцээгүй 23.3 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээг төлөвлөж, техникийн тодорхойлолтыг хууль, журмын дагуу боловсруулж, батлуулаагүй төлөвлөсөн 1 төсөл, арга хэмжээ байна.

ЗӨВЛӨМЖ: Төсвийн хөрөнгө оруулалтын үр ашгийг сайжруулж, техникийн тодорхойлолтыг хууль, журамд нийцүүлэн боловсруулж, батлуулах, “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах тайлагнах журам”-ын 3.5, 3.6-д зааснаас бусад төсөл, арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөхгүй байх.

САНАЛ: Холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд нийцүүлж төлөвлөөгүй 325.0 сая төгрөгийн 3 төсөл арга хэмжээг хасах, техникийн тодорхойлолтод сайжруулалт хийж, батлуулах шаардлагатай 23.3 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээ байна.

Авто замын сан:

Аймгийн 2024 оны төсвийн төсөлд 1,575.8 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 5 төсөл арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөсөн байна. Үүнээс өмнөх оноос шилжиж ирсэн 300.5 сая төгрөгийн 2 төсөл, арга хэмжээ байна.

Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.7 “бодитой байх”, Төсвийн тухай хуулийн 6 дугаар зүйлийн 6.4.1 “Төсвийг үр ашигтай, хэмнэлттэй байхаар төлөвлөж, зарцуулах” гэж заасан. Авто замын сангийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээний жагсаалтын 1.3.2.1 дэх 98.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй “Авто замын засвар арчлалтын техник, тоног төхөөрөмж” төсөл, арга хэмжээг төсвийн төсөлд бодит судалгаагүй, өндөр төсөвт өртөгтэйгөөр тусгасан байна.

ДҮГНЭЛТ: Авто замын сангийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтад техникийн тодорхойлолтыг хууль, журмын дагуу боловсруулж, батлуулаагүй төлөвлөсөн 1 төсөл, арга хэмжээ байна.

САНАЛ: Авто замын засвар арчлалтын техник, тоног төхөөрөмж” төсөл, арга хэмжээний 98.0 сая төгрөгийн төсөвт өртөгтэй 1 төсөл арга хэмжээг төсвийн үр ашгийг нэмэгдүүлэх зорилгоор техникийн тодорхойлолтод сайжруулалт хийж, батлуулах шаардлагатай байна.

Хөдөө аж ахуйн сан:

Хөдөө аж, ахуйн сангийн хөрөнгөөр 2024 оны төсвийн жилд хэрэгжүүлэх төсөл, арга хэмжээнд нийт 5 төсөл арга хэмжээг төлөвлөсөн байна.

“Арван мянган хүлэмж” 719.5 сая төгрөгийн төсөл арга хэмжээ нь Төрийн хэмнэлтийн тухай хуулийн 4 дүгээр зүйлд заасан зарчим 4.2.6-д “үндсэн чиг үүрэг, үйл ажиллагаатай холбоогүй хандив, тусламжийн шинжтэй зарлага, санхүүжилт гаргахгүй байх”, 13 дугаар зүйлийн 13.3.2-т “хувийн өмчид шилжих, улсын болон орон нутгийн өмчид бүртгэх боломжгүй, нийтийн зориулалттай бус ашиг олох зорилготой төсөл, арга хэмжээ” Төсвийн тухай хуулийн 25 дугаар зүйлийн 25.10-т “Төрийн болон орон нутгийн өмчит хуулийн этгээд хандив, тусламж өгөхийг хориглоно” гэсэн заалтуудтай нийцэхгүй байна.

ДҮГНЭЛТ: Хөдөө аж, ахуйн сангийн хөрөнгөөр 2024 онд хэрэгжүүлэх төсөл арга хэмжээний жагсаалтад Төрийн хэмнэлтийн тухай хууль болон Төсвийн хуулийн хориглосон заалтыг зөрчсөн 1 төсөл, арга хэмжээ байна.

ЗӨВЛӨМЖ: Төсвийн тухай хууль болон Төрийн хэмнэлтийн тухай хуульд нийцэхгүй төсөл, арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөхгүй байх.

САНАЛ: Холбогдох хууль тогтоомж, дүрэм журамд нийцэхгүй байгаа 719.5 сая төгрөгийн төсөл арга хэмжээг хасах санал оруулж байна.

Халамжийн сан:

Аймгийн 2024 оны төсвийн төсөлд халамжийн үйлчилгээ үзүүлэхэд 2023 оноос 19.0 хувиар бууруулж 185.0 сая төгрөгийг халамжийн Олон нийтийн оролцоонд түшиглэсэн халамжийн үйлчилгээ болон Онцгой тохиолдлын мөнгөн тэтгэмж зарцуулахаар төлөвлөсөн байна

Халамжийн сангийн 2023 оны хүлээгдэж буй гүйцэтгэлээр 228.6 сая төгрөгийг зарцуулж 62.1 сая төгрөгийн үлдэгдэлтэй байна.

Аймгийн 2024 оны төсвийн төсөлд аймгийн ИТХ-ын шийдвэрээр 2023 оноос шилжин ирсэн 5,053.9 сая төгрөгийн 30 төсөл арга хэмжээнээс 270.0 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээ 182.0 сая төгрөг болж буурч, 585.0 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээ 631.8 сая төгрөг болж нэмэгдсэн байна.

Төсвийн тэнцэл:

“Төсвийн тэнцэл” гэж тухайн төсвийн жилийн төсвийн нийт орлого, зарлагын зөрүүг хэлнэ. /Төсвийн тухай хуулийн 4 дүгээр зүйлийн 4.1.11./

Аймгийн 2024 оны төсвийн тэнцвэржүүлсэн орлого ба тусламжийг 92,348.4 сая төгрөг, тэнцвэржүүлсэн зарлагыг 89,371.9 сая төгрөгөөр тооцож, төсвийн тэнцлийг 2,976.5 сая төгрөгийн ашигтай байхаар боловсруулсан нь Төсвийн тухай хууль болон бусад хууль тогтоомжид заасан шалгуурыг хангаж байна.

ДҮГНЭЛТ:

1. Аймгийн 2024 оны төсвийн төсөл нь аймгийг хөгжүүлэх таван жилийн үндсэн чиглэл, аймгийн хөгжлийн жилийн төлөвлөгөөтэй нийцсэн байна.
2. Төсвийн төслийг аймгийн хөгжлийн төлөвлөгөө, Сангийн яамны хянасан төсвийн хязгаартай уялдуулан 2024 оны төсвийн тэнцлийг 2,976.5 сая төгрөгийн ашигтай байхаар боловсруулсан байна.

3. Аймгийн 2024 оны төсвийн орлогыг өмнөх оноос 13,858.6 сая төгрөг буюу 18 хувиар нэмэгдүүлэн төлөвлөсөн байна.
4. Төсвийн төсөлд Төрийн хэмнэлтийн тухай хуулийн хэмнэлтийн горим хэрэгжүүлэхэд баримтлах зарчим, Төсвийн тухай хуульд заасан шалгуурт нийцүүлэн арвилан хэмнэлттэй, үр ашигтай, үр нөлөөтэй, төсвийн урсгал зардлыг хэмнэх, төсөл, арга хэмжээг эдийн засгийн үр ашигтай, нийгэмд ач холбогдолтой байхаар хүрэх үр дүнг тооцож төлөвлөөгүй 3.2 тэрбум төгрөгийн 21 төсөл арга хэмжээ байна.
5. Өмнөх оны аудитаар өгсөн зөвлөмжийн биелэлт 84.0 хувьтай байна.

ЗӨВЛӨМЖ:

Аудитын дүн, дүгнэлтэд үндэслэн дараах зөвлөмжийг хэрэгжүүлэхийг Дорнод аймгийн Засаг дарга /М.Бадамсүрэн/-д үүрэг болгож байна.

1. Засгийн газраас тогтоосон болон Сангийн яамны хянасан бүтэц, орон тооны хязгаарыг баримтлан боловсруулж, төлөвлөх.
2. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт, Авто замын сан, Хөдөө аж ахуйн сангийн хөрөнгөөр хэрэгжих төсөл, арга хэмжээг Төрийн хэмнэлтийн тухай хууль, Төсвийн тухай хууль, Төрийн болон орон нутгийн өмчийн тухай хуульд нийцүүлэн, тухайн шатны төсөвт хамаарахгүй төсөл, арга хэмжээг хэрэгжүүлэхээр төлөвлөхгүй байх.
3. Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх зардлын хөрөнгөөр хэрэгжих төсөл арга хэмжээг төлөвлөхдөө “Байгаль орчныг хамгаалах, нөхөн сэргээх арга хэмжээнд зарцуулах төлбөрийн орлогын хэсгийг бүрдүүлэх, зарцуулах тайлагнах журам”-ын 3.5, 3.6-д зааснаас бусад төсөл, арга хэмжээнд зарцуулахаар төлөвлөхгүй байх.

Зөвлөмжийн биелэлтийг 2024 оны 5 дугаар сарын 01-ний дотор, Төрийн аудитын тухай хуулийн 20 дугаар зүйлийн 20.5-т “Шалгагдагч этгээд болон холбогдох бусад албан тушаалтан нь энэ хуулийн 20.2-т заасан зөвлөмжийн мөрөөр авч хэрэгжүүлэх арга хэмжээний төлөвлөгөөг аудитын тайланг хүлээн авснаас хойш 30 хоногийн дотор төрийн аудитын байгууллагад ирүүлнэ” гэж заасан хугацаанд тус тус ирүүлэх.

ИРГЭДИЙН ТӨЛӨӨЛӨГЧДИЙН ХУРАЛД

1. Төсвийн зарлагыг бууруулах – 1,063.3 сая төгрөгийн 5 төсөл, арга хэмжээ байна.
 - 1.1. Засаг даргын зөвлөхийн 1 орон тоо – 18.8 сая төгрөг
 - 1.2. Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал – 325.0 сая төгрөгийн 3 төсөл, арга хэмжээ
 - 1.3. Хөдөө аж ахуйн сан – 719.5 сая төгрөгийн 1 төсөл арга хэмжээ
2. Төсвийн үр ашгийг сайжруулах – 2,121.3 сая төгрөгийн 16 төсөл, арга хэмжээ байна.
 - 2.1. Орон нутгийн төсвийн хөрөнгө оруулалт – 1,455.1 сая төгрөгийн 8 төсөл, арга хэмжээ
 - 2.2. Хөрөнгө оруулалтын бус хөтөлбөр төсөл арга хэмжээ – 463.4 сая төгрөгийн 5 төсөл, арга хэмжээ
 - 2.3. Орон нутгийн хөгжлийн сан – 81.5 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээ
 - 2.4. Байгаль орчныг хамгаалах нөхөн сэргээх арга хэмжээний зардал – 23.3 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээ
 - 2.5. Авто замын сан – 98.0 сая төгрөгийн 1 төсөл, арга хэмжээ

Дорнод аймаг дахь Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторын тушаал.



ДОРНОД АЙМАГ ДАХЬ
ТӨРИЙН АУДИТЫН ГАЗРЫН ДАРГА,
ТЭРГҮҮЛЭХ АУДИТОРЫН
ТУШААЛ

2023 оны 12 сарын 01 өдөр

Дугаар 437

Чойбалсан хот

Г

Тайлан баталгаажуулах тухай

Г

Төрийн аудитын тухай хуулийн 29 дүгээр зүйлийн 29.2, 29.4 дэх заалт, Монгол Улсын Ерөнхий аудиторын 2020 оны А/106 дугаар тушаалаар батлагдсан "Төрийн аудитын байгууллагаас аудит хийх журам"-ын 18.9, 2023 оны А/102 дугаар тушаалаар батлагдсан аймаг, нийслэл дэх Төрийн аудитын газрын дарга, тэргүүлэх аудиторт шилжүүлэх эрх, үүргийн 1.4 дэх заалтыг тус тус үндэслэн ТУШААХ нь:

1. Дорнод аймгийн 2024 оны төсвийн төсөлд дүгнэлт өгөх аудитын тайланг хавсралтаар баталсугай.

2. Аудитын тайланг Үндэсний аудитын газрын Аудитын нэгдсэн удирдлага, зохицуулалтын газрын захирал, тэргүүлэх аудитор (Я.Самбууням), аймгийн иргэдийн Төлөөлөгчдийн Хурлын дарга (М.Энхтөр), аймгийн Засаг дарга (М.Бадамсүрэн) нарт хүргүүлсүгэй.

3. Аудитаар өгсөн зөвлөмжийг хэрэгжүүлэх арга хэмжээ авч, биелэлтийг 2024 оны 05 дугаар сарын 01-ний дотор Дорнод аймаг дахь Төрийн аудитын газарт ирүүлэхийг аймгийн Засаг дарга (М.Бадамсүрэн)-д үүрэг болгосугай.

4. Аудитаар өгсөн зөвлөмжийн хэрэгжилтэд хяналт тавьж ажиллахыг аудитын менежер (И.Сэмжидмаа)-д даалгасугай.



Б.БОЛОРТУУЛ

011010105